

**Монголын орчин үеийн жүжгийн ууган зохиолч,
анхны жүжгийн онолч С. Буяннэмэх**

*Ван Мандуга
(БНХАУ, Төвийн Үндэсний Их Сургууль)*

Агуулгын товч: Тус өгүүлэлд С. Буяннэмэхийн монголын орчин үеийн театрын урлагийг анх үүсгэн буй болгоход жинтэй хувь нэмэр оруулсан бодит зүтгэл чармайлга, уйгагүй хөдөлмөр оюун зарцуулж аль олон жүжгийн зохиол туурвин бичиж театр клубуудыг ши жүжгийн зохиолоор хангаж байсан ба жүжгийн зохиолын онол үзэлтээрээ жүжгийн зохиолчдыг боловсруулан бэлтгэхэд чухал үйлдэл үзүүлж байсан зэрэг хэдэн талаар нягтлан шинжилж, С.Буяннэмэх бол монголын орчин үеийн жүжгийн ууган зохиол, анхны жүжгийн онолч мөн гэдэг үзэл баримтлалаа дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Монголын орчин үе, ши жүжиг, С. Буяннэмэх, ууган зохиолч.

Монголын орчин үеийн хувьсгалт жүжгийн үүсэл хөгжлийн түүхэнд С. Буяннэмэхийн оруулсан хувь нэмэр бол маш их бөгөөд хэн ч орлож боломгүй чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тэрээр монголын орчин үеийн хувьсгалт жүжгийн анх үүсвэрийн тулгын гурван чулууг тавилцсан бөгөөд монголын театр урлагийг үүсгэн хөгжүүлэх анхан үеэс нь удирдах, зохион байгуулах ажилд идэвхийлэн оролцож, анхны жүжгийн найруулагч болсон юм.

1922 оны 2 дугаар сард МХЗЭ-ийн Түр Засгийн Төв Хорооноос сэдэн санаачилсаныг Монгол Ардын Намын Төв Хороо зөвшөөрөн дэмжснээр нийслэл хүрээнд дуу, хөгжим, жүжгийн дугуйлан байгуулагдаж, улс төр уран сайхны талаар хариуцан хянагчаар С. Буяннэмэхийг томилж монголын орчин үеийн театрын урлагийн анхны үүсвэрийг буй болгосон байна. Тус бүлгэмийн анхны бүтээл нь С. Буяннэмэхийн бичсэн “Сандо амбан” (“Ойрхи цагийн товч түүх”)[1] хэмээх жүжиг болно. Монголын ард түмэн манжийн засгийн газраас томилсон хамгийн сүүлчийн амбан ноён Сандог Монгол нутгаас үлдэн хөөж, гамин бароны цэргийг бут цохиж, ардын хувьсгал ялж, мандсныг харуулсан “Сандо амбан” жүжгийг 1922 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Народомд амжилттай тоглосон байна[2]. Бүлгэмийнхэн эхэн үедээ ардын аман зохиолоос үндэслэн жүжиг үзэгдлүүд хятадын ши янгууг найруулан тоглож байв.

С.Буяннэмэх энэ бүхэнд тэргүүлэх үүрэгтэй оролцож байсан бөгөөд ийм жүжгийг ийнхүү монгол хэлээр тоглосон нь монголын үндэсний жүжиг зохиол буй болох эхлэл болсон байлаа. Цухас тэмдэглэхэд, тухайн үед монголын цэргийн сургуулийн комиссар байсан Н.Насанбат “Гэсэрийн тууж”-аас үндэслэн “Агдулам хаан” гэдэг зохиолыг бичиж, түүнийг С.Буяннэмэх найруулж тоглуулжээ. Энэ нь монголд говийн ноён хутагт Данзанравжаагаас хойш хэн ч жүжиг найруулж байсангүй тул С.Буяннэмэх нь монголын орчин үеийн жүжгийн анхны найруулагч болох ажээ. 1922-1937 он хүртэлх 15 жилийн дотор С.Буяннэмэх бээр уйгагүй зүтгэл чармайлгаар 21 жүжиг буюу жүжгийн товчоог туурвин бичиж театрт тавьж, монголын ши жүжиг театр урлагийн хөгжилд онцын хувь нэмэр оруулсан байгаа. Одоо бидэнд олдсон жүжгийн зохиолоос нэгэнтээ ном болж хэвлэгдсэн нь “Ойрхи цагийн товч түүх”(буюу “Сандо Амбан”), “Монголыг хүрээлсэн эзэрхэг улсуудын хоорондын байдлыг товчлон үзүүлсэн түүх”[3], “Баатар хөвгүүн Тэмүүжиний жүжиг”[4], “Марал шарын жүжиг”[5] “Шөнийн буг”[6], “Харанхуй засаг”[7], “Эрдэнэт Соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар”[8] зэрэг 7 жүжиг буй. Бичмэл буюу машиндмал эхээр олдоод байгаа нь “Сандо Амбаны ши нь бичиг”(найман бүлэгтэй бүрэн эх)[9], “Шийдвэрийн даваан дээр”(жүжиг үйлдэх төлөвлөгөө)[10], “Үхэлийн дундаас даваадвай”(Хоёрдугаар жүжгийн төлөвлөгөө)[11], “Ардын долоон баатар”(жүжгийн товч, АВС гурван бичмэл эх)[12], “Долоон сайн эр”(жүжиг бичих төлөвлөгөө, АВ хоёр бичмэл эх)[13], зэрэг таван жүжгийн товчоо, төлөвлөгөө сэлт буй. Бас уг эх нь олдоогүй жүжгийн зохиол нь “Үнэн”[14], “Арван жил”[15], “Усгүй хар архи”[16], “Гурван хорын хүлээс”[17], “Хоршоо жингийн дуу”[18], “Сэрэмж”[19], “Хар барс”[20], “Нутаг усны тэмцэл”(буюу “Уран чимэг”)[21], “Нэгэн өдрийн доторхи аймшиг”(буюу “Нэгээхэн өдрийн хооронд”)[22] зэрэг 9 зохиол буй. Эдгээр 21 жүжгийн дотроос 16 нь бүтэн зохиолоор хэвлэгдсэн буюу театрт тавигдсан байна. 5 нь зохиолын товчоо буюу төлөвлөгөө маягтай бүтэн бус зэрэмдэг зохиол болох юм. Мөн эдгээр жүжгийн зохиолуудын дотор цөөн бус бүтээл нь удаа дараалан үе тэнгийн зохилчдын зохиол бүтээл дотроос цолгорон гарч төр засгийнхаа шагнал хөхүүлэлийг хүртэж, түмэн олныхоо халуун талархалыг хүлээсээр байжээ. Тухайлбал, түүний бичсэн хоёрдахь жүжиг “Монголыг хүрээлсэн эзэрхэг улсуудын хоорондох байдлыг товчлон үзүүлсэн түүх” нь 1924 онд Судар Бичгийн Хүрээлэнгийн тэргүүн шагнал 115 ланг тосжээ. (Жүжгийн зохиол бичсэн учир Д.Нацагдорж, Гомбожав нарт 50 лан, түүхэн жүжиг зохиосон учир Насанбатад 35 лан шагнав). 1934 онд болсон “Монголын эрэлхэг байдлыг товчлон баатарлаг үндэсний хувьсгал, түүний удирдагч Сүхбаатарын тухай” жүжгийн зохиолын уралдаанд С.Буяннэмэхийн “Эрдэнэт Соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар” хэмээх жүжиг нь тэргүүн байрт шалгарч 1500 төгрөгөөр шагнагдав. (Тус уралдаанд Ш.Аюушийн “Монгол хүү” хэмээх жүжиг хоёрдугаар байрыг эзлэж, М.Ядамсүрэнгийн “Халхын баатар” хэмээх жүжиг гуравдугаар байрт оржээ). 1933 онд Москвад болсон олон улсын олимпиад наадамд Монгол улсын театр нь С.Буяннэмэхийн “Харанхуй засаг” хэмээх жүжгийг тоглож тэргүүн байр эзэлж (зарим мэдээнд хоёрдугаарт оров гэдэг), Монгол театр урлагийг олон улсын хэмжээнд сайхан нэртэй болгов.[23] 1936 онд хоршоочлолын 15 жилийн ойд зориулсан жүжгийн уралдаанд С.Буяннэмэхийн бичсэн “Хоршоо жингийн дуу” хэмээх жүжиг нь мөн тэргүүн байрт шалгарав. (Хоёрдугаар байрыг Намдагийн “Мөлжигч ба туслагч” хэмээх жүжиг, гуравдугаар байр нь Пүрэвийн “Баттай хөрөнгө” хэмээх жүжиг, дөрөвдүгээр байр нь Санжидын “Нэгдэлд хүчин оршмой” хэмээх жүжиг тус тус эзэлжээ).

Дээр дурдсанаас үзэхэд С.Буяннэмэхийн бичсэн жүжгийн зохиолын тооны талаар ч тэр, чанарын талаар ч тэр, агуулга үзэл санааны талаар ч тэр, урлаг уран сайхны нээлтийн талаар ч тэр, бүр тухайн нэгэн үеийнхээ дотор тэргүүн эгнээнд хошуучлан явж, ши жүжгийн театр урлагийн хөгжилд өөрийн жинтэй хувь нэмрээ оруулжээ. Яг ийм учраас 1935 онд “Улсын бага хурлын тэргүүлэгчид ба ардын сайд нарын зөвлөлийн гишүүд хамтран хуралдсан хурлаар гаргасан тогтоол”-д: “...Нөхөр С.Буяннэмэх болбоос Монголын үндэсний уран сайхны ажлыг анх үүсгэн буй болгох явдалд тэргүүлэн оролцож явсан төдийгүй одоо хүртэл үндэсний уран зохиол найруулга, ши жүжгийн ажилд онцоор идэвхийлэн оролцож өдий төдий уран сайхан бүтээлүүдийг үйлдэж гүйцэтгэсэн бүхий тул... улсын гавьяат алдарт уран зохиолч хэмээх цол ба дурсгалын эдээр шагнахын хамтад ... уран сайхны ажлын онц гавьяаны үнэмлэхийг олгосугай...”[24] гэж бичсэн бөгөөд сонинд нийтлэсэн С.Буяннэмэхийн цээж зургийн нь хажууд: “Тус улсын хувьсгалын уран сайхан, ши жүжиг тэргүүтний анхны үүсгэлч бөгөөд эдүгээх нэрт зохиолч, мөнөөхөн улсын алдарт гавьяат уран зохиолч хэмээх цол шагнагдсан нөхөр С.Буяннэмэх”[25] хэмээн маш зөв зүйтэй тодорхойлон бичжээ. 1934 оны 4 дүгээр сард Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны 45 дугаар хурлын шийдвэрээр С.Буяннэмэх, Их Нацагдорж хоёрыг Төв театрын тусгай орон тооны зохиолчоор томилон ажлуулжээ.[26] 1964 онд хуралдсан Монголын Зохиолчдын III их хурал дээр Монголын Зохиолчдын Эвлэлийн нэгдүгээр нарийн бичгийн дарга С.Удвал тайлан илтгэлдээ: “... С.Буяннэмэх мэргэжлийн театр байгуулах, театр уран сайхны газрыг ши жүжгийн зохиолоор хангахад анхаарал тавьж явсан нь илэрхий. Түүний зохиосон “Үнэн”, “Эрдэнэт Соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар”, “Харанхуй засаг”, “Шөнийн буг”, “Гурван хорын хүлээс” зэрэг жүжиг нь манай театрын тайзан дээр олон удаа гарч байжээ...”[27] гэж зүй ёсоор тэмдэглэжээ. С.Буяннэмэхийн зохиосон жүжгийг театрт тавьж байсан тухай ганц нэг баримт дурдахад, “Ардын цэнгэлдэх улсын төв театрын энэ 24 ба 25 оны өвөл цагийн улиралд явуулах ажлын төлөвлөгөө”[28]-д: “...Энэ өвлийн улиралд хуучин шинэ жүжгүүд ба кино зэргийг гаргахаар төлөвлөсөн нь:

1. Харанхуй засаг	4 удаа
2. Учиртай гурван толгой	5 удаа
3. Би биш	4 удаа
4. Өвгөн бүргэд	5 удаа
5. Сүхбаатар Буяннэмэхийн зохиол	7 удаа

Хуучин ши бүгд 25 удаа, шинэ ши 43 удаа, мөн дуу хөгжим элдэв сонирхолтой үдэш 8 удаа тус тус гаргахаас гадна, кино зургийн талаар зохих эрхлэх газруудаас хангалттай сайнаар бэлтгэн чадах ахул долоо хоног бүрт 2 удаа гаргаж байхаар төлөвлөсөн амой. Эдгээр гаргахаар төлөвлөсөн жүжиг ба кино нь 25 оны 6 сарын 1 хүртэл гүйцэтгэх болно...”[29] гэж бичсэн байдаг. Энэхүү 1934 оны 12 сараас 1935 оны 6 сар болтол хагас жилийн хугацаанд Төв театрт тавих хуучин ши жүжиг нийт 5 жүжиг, бүгд 25 удаа тавьх болно, үүний дотор С.Буяннэмэхийн хоёр жүжиг, 11 удаа тавигдахаар төлөвлөжээ. Тэр нь нийтдээ тавих жүжгийн зууны дөчин хувь, жүжиг тавих удаагийн зууны дөчин дөрвөн хувийг эзлэж байна. Үүнээс үзэхэд С.Буяннэмэхийн зохиосон жүжиг тухайн үед монголын театрт маш олон удаа тавигдаж байсан гэдэг нь тодорхой. Тэрээр хамаг олонтоо мэдрэгдсэн бөгөөд гүн талархалыг нь хүлээсэн ууган зохиолч байсан нь үнэн болно.

С.Буяннэмэх нь монголын орчин үеийн жүжгийн ууган зохиолч байсан төдийгүй анхны жүжгийн онолч болох юм. Тэрээр “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв”[30], “Театрын уран сайхны тухай”[31], “Утга зохиолын үүд”[32], “Тус улсын 15 жилийн ой ба үндэсний уран сайхны 15 жилийн хөгжил”[33] зэрэг өгүүлэл зохиолдоо жүжгийн онолын асуудлыг өгүүлэв. С.Буяннэмэхийн жүжгийн онол нь түүний шүлэг зүй, туужисын онолтой харицуулбал хуудас хэмжээгээр ялимгүй бага байдаг. Гэвч тэрээр жүжгийн зохиолын тухай онолын үндсэн асуудлуудыг гол төлөв хөндөж, өөрийн үзэл онолоо товч тодорхой дэвшүүлсэн байна. Түүний жүжгийн зохиолын тухай онол үзэлт их төлөв жүжгийн зохиолын давуулаг тал, жүжгийн зохиолын утга сэдэв, жүжгийн зохиолын төрөл ангилал, жүжгийн зохиолын урлаг ба зохиомжийн онцлог, жүжгийн зохиолыг зохион туурвих арга гэх зэрэг хэдэн талтай холбогдоно.

Нэг. Жүжгийн зохиолын давуулаг талын тухай тэрээр уран зохиолын гурван их аймаг сав-яруу найраг, туужис, жүжгийн дотор жүжиг нь хамгийн эрхэм чухаг зүйл болно гэж үзээд “...ши жүжгийн зохиол бүтээл болвоос ард олны боловсрол ба уншигчдад онц тустай эрхэм зүйлийн нэг болой. Түүний тус нь юунд буй хэмээвээс хэдэн зүйл буй. Нэгд: хэлээд яриад хүнд мэдрүүлэхүйд бэрхтэй зүйлийг биеэр үзүүлэн маш хялбараар мэдүүлж болмой. Хоёрт: бичиг мэдэхгүй хүн боловч жүжгийг үзэхүйд үлгэрийг уншсан лүгээ адил. Гуравт: ши жүжгийн зохиолыг энгийн цагт үлгэр түүх мэт уншиж болмой...”[34] гэж бичжээ.

Энд жүжгийн зохиолын онцлог буюу давуутай талыг гурван талаар хураангуйлжээ. Тухайлбал: 1. Үг хэлээр яриад хүмүүст мэдрүүлэхэд бэрх зүйлийг бие галбирын хөдлөл барилаар маш хялбархан мэдүүлж чадна; 2. Бичиг үсэг мэдэхгүй хүмүүс ч жүжгийг сонирхож чадна; 3. Жүжгийн зохиолыг энгийн цагт яг үлгэр туульсын зохиол мэт уншиж сонирхож болно. Ийм учраас жүжиг нь “Ард олныг элдэвт танилцуулан боловсруулахүйд маш эрхэм тустай ойр нөхөр нь мөн”[35] гэж үзжээ. Жүжгийн зохиолыг хэний төлөө бичих зорилгын тухай тэрээр “элдэв ши жүжгийг зохиоход юуны өмнө ядуу дунд ардын эрх ашгийг хамгаалах эрдэм соёлыг хөгжүүлэхүйд чухал зэвсэг болгохыг гол болгож хувьсгалын утга чанарт нийлүүлэн зохиовоос зохимой”[36] гэж зөв оновчтой заасан юм. “Ядуу дунд ардын эрх ашгийг хамгаалах эрдэм соёлыг хөгжүүлэх”-ийн төлөө жүжгийн зохиол бичих зорилго бол тухайн үеийн монголын хувьсгалт уран зохиолын намч, ардач, ангич чанарын зарчимтай нийцэж байх юм.

Хоёр. Жүжгийн зохиолын үндсэн утга сэдвийг ард түмний ашиг тусд хандуулахыг тэргүүн байрт тавив. Тэрээр “Гагцхүү түүний үндсэн утга нь эс бөгөөс ардын эрх ашгийг хамгаалах зүйлд холбогдох, эс бөгөөс ард олонд таниулж мэдүүлэх эрдмийн зүйлд холбогдох, эс бөгөөс сайн муу байдал хүний явдлуудыг гарган ирүүлж ятган таниулах утгатай болвоос цөм болох болой”[37] гэж ард түмний эрх ашгийг хамгаалах, ард олонд таниулан мэдүүлж, эрдэм соёлыг хөгжүүлэх, сайн муу байдал болон хүний явдлыг тусган харуулж, хүмүүсийг ятган таниулах зэрэг гурван үндсэн утга сэдвийг жүжигт харуулахыг чухалчилав. Үүний эхний хоёр зүйл нь утга тодорхой ойлгомжтой тул олон нуршууг гамная. Сайн муу байдлын харуулал ба хүний явдлыг тусган харуулах хэмээгч юуг хэлсэн буй гэвэл, хүний нийгмийн амьдралын өргөн

хүрээг хамарсан зүйл болох юм. Хүний нийгмийн амьдралд сайн муу зүйл ямагт холилдон хутгалдан оршиж хоорондоо цаг үргэлж харилцан зөрчилдөн тэмцэлдэж байдаг жишээтэй. Иймэрхүү утга сэдэв бүхий зүйлийг жүжигт харуулан үзүүлж хүмүүсийн юуг үнэн, сайн, сайхан гэж үзэх, юуг худал, муу, муухай гэж үзэх үзэл танилтыг ухамсарлуулан дээшлүүлэх нь маш чухалтай байдаг юм. Энэ нь хүмүүсийн улс төр, ёс суртахуун гоо сайхны үзэл танилттай бүр нягт холбогдоно. Мөн “хүний явдал” хэмээгч хүний амьдралын явдлыг заадаг, даруй хүний нийгэмд оршин амьдрахуйн төлөөний бүх үйл ажиллагаа, үзэл бодол, үг яриа соёл заншилын зүйлүүдийг багтаасан маш өргөн агуулга бүхий ухагдахуун мөн. Хүний амьдрал явдлыг тусган харуулах бол жүжгийн зохиолын хамгийн үндсэн утга сэдэв болно.

Гурав. Жүжгийн зохиолын төрөл ангилалын тухай тэрээр “... жүжгийн зохиол бол гурван ялгавартай болой. Нэг. Үнэн байдлын зохиол хэмээнэ. Тэр нь ямар хэрэг, яасан гарсан аваас тэр хэвээр шахам бичих болой. ... Үүнд онц уран сайхан гэх төдий л үгүй хэмээгдэнэ. Нөгөө зүйл нь урлан бичих зохиол хэмээнэ. Тэр нь үнэн болсон ямар нэгэн сонин хэргээс сэдэв авах буюу байж болох хэргүүдийг сэдэвлэж, түүнийхээ үзэгдэл бүрд онц сонирхолтой бүхий хөдөлгөөн тэмцэл уран арга санаачлагыг өргөнөөр нэмэгдүүлэн зохиож жинхэнэ уран сайхан жүжгийн найруулга болгоно. Гуравдахь нь жишээлсэн зохиол хэмээнэ. Үүнийг цөм өөрийн санаачлагаар зохиох бөгөөд хүний байдлыг хүний дундаас ялгавартай өөр нэг билэг тэмдэг ба гайхалтай сонинор бичих мэт болой...”[38] гэж бичээд, жүжгийн зохиолыг үнэн байдлын, урлан бичсэн, жишээлсэн гэх гурван зүйлийн ялгавар байна гэж үзжээ. Энэ бол амьдрал ба уран зохиолын харилцаанаас жүжгийн зохиолыг зүйл хуваан ялгаварласан байгаа юм. С.Буяннэмэхээр бидний одоогийн зохиолын онолд ярьдаг “тунигт жүжиг”, “хошин жүжиг”, “төв жүжиг” гэж гурван төрөл ангилалтай дүйцэн “уяралт жүжиг”, “инээдмийн жүжиг”, “ердийн жүжиг” гэх гурван төрөл ангилалаар тайлбарласан нь утгын хувьд зөв зүйтэй бөгөөд Европ дахины уламжлалт төрөл ангилалтай төлөв нийцэж буй. Тэр бас опер(уянгат) хэмээх дуурийн тухай өөрийн үзэл ойлголтоороо тайлбарлаж, анх жүжгийн зохиол бичиж байгаа хүмүүст тус дэмжлэг болохыг хичээжээ. Тэрээр “Опер хэмээх... тийм уянгат жүжгийг зохиох ба найруулахад зүйл бүрийн хөгжим эгшиг аялгуунууд ба элдэв зүйлийн бүжиг наадам ба тайзны байдлын гоё сайхан чимэг, өнгө үзэсгэлэнт зүйлүүд энэ бүхнийг хамтруулана. Нөгөөтэйгүүр жүжигт тоглох байдал нь ганхалзуур дэнхэлзүүр болох, хэлэх ярих нь цөм шүлгийн үгсээр дуулах ба олон төрлийн байдлууд хамтарч жигдрэх ба дуу чимээ маш сүрлэг гоё буюу эсхүл уяралт зөөлөн, эсхүл хөгжил баясгалан, инээдэм цэнгэлээр дүүрнэ. Ийм байдлуудыг хамтруулан зохиох зохиол болой”[38] гэж тайлбарлаад, иймэрхүү жүжгийг бичих ба найруулахад хэдийгээр хүчиртэй мэт боловч бага зэрэг эгшигтэй жүжигүүдийг зохиож байн байсаар уянгат жүжгийг зохиоход болно гэж өгүүлжээ. Эгшигтэй жүжиг гэдэг нь тэр үеийн театрт тавигдаж байсан “Сандо амбан”, “Харанхуй засаг”, “Хатан Долгор Харц Дамдин” гэх мэтийн бага зэрэг дуутай хөгжимтэй эгшигт жүжгийг зааж, уянгат жүжиг гэгч нь одоогийн опер буюу дуурийг заан нэрлэж байжээ. С.Буяннэмэх бээр “Ер монголын ши жүжиг уран сайхны үүсэлүүд нь их төлөв дуутай хөгжимтэй хослуулан наадах байдлаар үүссэн бөгөөд тэр мэт дуутай ши жүжиг нь үзэгчдийн сэтгэл зүрхийг нэлээд хөдөлгөж чаддаг байсан...”[39] гэж Монгол жүжгийн үндэсний онцлогийг түүний бодит практиктай уялдуулан шинэлэг үзэлт дэвшүүлсэн нь монгол жүжиг судлалд ач холбогдолтой болсон юм.

Дөрөв. Жүжгийн зохиолын урлагийн онцлогийн тухай С.Буяннэмэх голдуу гурван талыг чухалчилж байжээ. Тухайлвал, 1. Жүжгийн тэмцэлийн байдал нь уран хурц; 2. Үзүүлэх хэмээсэн зүйл нь хэзээд ил тод; 3. Гадаад байдал ба дотоод утга хоёр нь зохилдож чадсан байх зэрэг болно. Нэгэн жүжгийн зохиол нь хэрэв энэ гурван талаар амжилттай болж чадсан байвал жүжиг зааварлагчаас урлан найруулж авахад нэн сайхан бөгөөд үзэгч олны үзэхэд маш сонирхолтой болдог гэж тэр үзжээ. С.Буяннэмэхээс жүжгийн зохиолын урлаг уран сайхны онцлогийн хамгийн чухал нь “Уул жүжгийн тэмцлийн байдлыг уран хурц” байх явдал болно гэж үзжээ. Энд ярьж байгаа тэмцлийн байдал гэдэг бол даруй бидний ярьдаг зөрчил мөргөлдөөнийг хэлж буй. Зөрчил мөргөлдөөн бол ши жүжгийн зохиолын гоо таашаахуйн амин чухал үндсэн онцлог болох юм. Зөрчил мөргөлдөөн байхгүй бол жүжгийн зохиол нь амилж чадахгүй. Жүжгийн үйл явдлыг урнаар зохиомжилж, эсэргүүцэлдсэн хоёр талын жүжгийн тэмцлийг хурц төвлөрөнгүй илрүүлэх бол жүжгийн зохиолын уран сайхны гол ёс болно. Түүний үзэхээр жүжгийн зөрчил тэмцэл бол зөвхөн дайн байлдаан, зодоон цохионы тэмцэл биш, тэр нь “...хүний амьдралын тул тэмцэх, эрх чөлөөний тул тэмцэх, элдэв явдлууд ба сайн сайхны тул, янаг амрагийн тул тэмцэх тэргүүтэн олон зүйлийн тэмцэл байна. Жишээлбэл, харанхуй байдалтай тэмцэх, зүй бус байдал лугаа тэмцэх, зовлонгоос гарахын тул тэмцэх зэрэг хүний хамаг явдал нь нарийвчилвал цөм төрөхөөс үхэх өдөр хүртэл тэмцлийн дунд явах байна. Бас нэгэн нарийн зүйл нь хүн сэтгэл лүгээ тэмцэх, сэтгэл нь хүн лүгээ тэмцэх ийм ч явдал байна...”[40] гэх мэтчлэн баялаг олон агуулгыг багтааж байх юм байна. Тэрээр жүжгийн зөрчил тэмцэлийн тухай нэлээд гүнзгий задлалт хийсэн байгаа юм.

Тав. Жүжгийн зохиолыг бичих арга барилын талаар, тэр гурван талаар цухас дурдав.

1. Жүжгийн байгуулалтыг харицуулан, төлөвлөн тэмдэглэж хоёр тэмцэгч этгээдийн манлайлагчийг тус тусд олж тохируулмагц бүхий л үзэгдэл ба явдал хэрэгүүдийг түүнийг тойруулж байгуулна.

2. Сонирхолтой хөдөлгөөн, сонирхолтой үг яриа ба сонирхолтой хэрэг явдлуудыг ямагт олж үзэгдэл бүхэнд баялагаар оруулахыг хичээх;

3. Үзэгдэл бүхний төгсгөлийг маш их тэмцэлтэй, уран сайхан, хүний сэтгэлийг эзэмдэн татаж дараачийн бүлгийг үзэхийг дурламаар төгсгөж байх зэрэг болно. Энд дурдагдсан “байгуулалт” гэдэг нь зохиомж бүтэц, “манлайлагч” гэдэг нь гол баатар, “явдал хэрэг” гэдэг нь үйл явдал зэрэг мэргэжилийн нэр томъёо болох юм.

Хураангуйлбал, С.Буяннэмэх нь монголын орчин үеийн театр жүжгийн анхны үүсвэрийг тавьж, сайн дурын жүжгийн дугуйлан байгуулахаас эхлээд мэргэжлийн театр байгуулах хүртэл, тэрчлэн ХХ-р зууны 30-аад оны сүүлч үе болтол монголын театрын урлагийг хөгжүүлэх үйлст шуудран зүтгэж, олон тооны чанар бүхий жүжгийн зохиолыг бичин туурвиж, театрыг зохиолоор хангасан; монголд хамгийн тэргүүнд театр ши жүжгийн онолын тухай ном зохиол бичиж, жүжгийн зохиолын тухай онол үзэлтээ тогтолцоотой дэвшүүлж байсан; монголын шинэ үеийн жүжгийн үүсэл

хөгжилд жинтэй хувь нэмрээ оруулсан ууган жүжгийн зохиолч анхны жүжгийн онолч болох юм.

Зүүлт

[1] С. Буяннэмэх “Сандо амбаны ши нь бичиг”, бичмэл эх, 45 хуудас, хэмжээ 21x27 см, 1923 оны 11-р сар. “Ойрхи цагийн товч түүх”(буюу “Сандо амбан”), Монгол улсын номын сангийн Монгол бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байгаа 5 дэвтэр бичмэл эх, 1922 онд бичиж, 1924 онд дахинтаа засаж бичсэн эх, “Монголын уран зохиолын дээжис” цувралын 23 дугаар боть, 1996 онд, Улаанбаатар хэвлэл, 245-312 дугаар нүүрт.

Ван Мандуга “С.Буяннэмэхийн хоёр жүжгийн гар бичмэл эх ба түүний судлал” ном, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2004 он, 94-195 дугаар нүүрт.

[2] “Уриа” хэмээх сэтгүүл, 1922 он, 16 дугаар хуудас, “Залуучуудын жүжиглэлийн тухай” хэмээх мэдээ, нийслэл хүрээ, 12 он монголын 3 сарын 12 өдөр, аргын улиралын 5 сарын 8 өдөр, Нийслэл хүрээний Орос Монгол хэвлэлийн хорооноо хэвлэв.

[3] С. Буяннэмэх “Монголыг хүрээлсэн эзэрхэг улсуудын хоорондын байдлыг товчлон үзүүлсэн түүх”, Монгол улсын нийтийн номын сангийн Монгол бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байгаа бичмэл эх, 1923 он,

Ван Мандуга “С.Буяннэмэхийн хоёр жүжгийн гар бичмэл эх ба түүний судлал” ном, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2004 он, 196-322 дугаар нүүрт.

[4] С. Буяннэмэх “Баатар хөвгүүн Тэмүүжиний жүжиг” 1923 оны үеэр зохиож, 1928 онд Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны хэвлэлээр тусгай ном болгон хэвлүүлэв. “Монголын уран зохиолын дээжис” цувралын 23 дугаар боть, 313-344 дүгээр нүүрт, 1996 он.

[5] С. Буяннэмэх “Марал шарын жүжиг”, 1924 онд бичиж, 1926 оны үеэр театрт тоглуулж, 1928 онд МАХН-ын Төв Хорооноос хэвлэн нийтлэв.

С.Буяннэмэх “Түүвэр зохиол”, 202-226 дугаар нүүрт, 1968 он.

[6] С. Буяннэмэх “Шөнийн буг”, 1931 онд зохиов, Монгол Улсын Ардын Гэгээрүүлэх Яамнаас 1934 онд хэвлүүлэв. Улаанбаатар хотоос кирилл үсгийн машиндмал эх олдov.

[7] С. Буяннэмэх “Харанхуй засаг”, 1933 онд зохиож, мөн онд театрт тавиулсан байна. 1933 онд Москвад болсон олон улсын театрын олимпиадад (их наадам)-д тус жүжгээр тэргүүн байрыг эзэлжээ. (зарим мэдээнд хоёрдугаар байр эзлэсэн ч гэдэг) С. Буяннэмэх “Түүвэр зохиол”, 1968 он, 180-201 дүгээр нүүрт.

[8] С. Буяннэмэх “Эрдэнэт Соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар”, 1934 онд бичив. Монгол улсын үндэсний төв архивт кирилл үсгийн машиндмал эхээр хадгалж буй. “Монголын уран зохиолын дээжис” цувралын 23 дугаар боть, 391-441 дүгээр нүүрт, 1996 он.

[9] С. Буяннэмэх “Сандо амбаны ши нь бичиг”, бичмэл эх, 45 хуудас, хэмжээ 21х27 см, 1923 оны 11-р сард засаж бичив. Монгол улсын номын сангийн Монгол бичмэл номын номын хөмрөгт хадгалагдаж буй.

[10] С. Буяннэмэх “Шийдвэрийн даваан дээр”, жүжиг үйлдэх төлөвлөгөө, Улаанбаатараас олдсон бичмэл эх.

[11] С. Буяннэмэх “Үхэлийн дундаас даваадбай”, хоёрдугаар жүжгийн төлөвлөгөө, Улаанбаатараас олдсон бичмэл эх.

[12] С. Буяннэмэх “Ардын долоон баатар”, жүжгийн товч, адилвтар гурван бичмэл эх, Улаанбаатараас олдсон бичмэл эх.

[13] С. Буяннэмэх “Долоон сайн эр”, жүжиг-бичих төлөвлөгөө, Улаанбаатараас олдсон хоорондоо адилвтар хоёр зүйлийн бичмэл эх.

[14] С. Буяннэмэх “Үнэн”, 1930 онд бичиж, 1931 оны 11 дүгээр сард ардын цэнгэлдэх хүрээлэнг улсын төв театр болгон өргөтгөн байгуулах үед тус жүжгийг тоглож нээлтээ хийжээ. Уг эх нь олдоогүй.

[15] С. Буяннэмэх “Арван жил”, 1930 оны үеэр театрт тавигдсан мэдээ буй, уг эх нь олдоогүй.

[16] С. Буяннэмэх “Усгүй хар архи”, 1930 оны үеэр театрт тавьсан мэдээ буй, уг эх нь олдоогүй.

[17] С. Буяннэмэх “Гурван хорын хүлээс”, 1931 онд бичиж, 1936 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр театрт тавьжээ. Уг эх нь олдоогүй.

[18] С. Буяннэмэх “Хоршоо жингийн дуу”, 1936 онд зохиов. 1936 оны 10 дугаар сард болсон жүжгийн уралдаанд тэргүүн байрыг эзлэжээ. Уг эх нь олдоогүй.

[19] С. Буяннэмэх “Сэрэмж”, 1936 онд зохиов. Уг эх нь олдоогүй.

[20] С. Буяннэмэх “Харбарс”, Уг эх нь олдоогүй

[21] С. Буяннэмэх “Нутаг усны тэмцэл”(буюу “Уран чимэг”), Уг эх нь олдоогүй.

[22] С. Буяннэмэх “Нэгэн өрийн доторхи аймшиг”(буюу “Нэгээхэн өдрийн хооронд”), бичмэл товчоо, Уг эх нь олдоогүй

[23] Ц. Дашням “Монгол улсын театр нь олон улсад сайхан нэртэй болов”, “Ардын үндэсний эрх” сонин, 1933 оны дугаар 66.

[24][25] “Ардын үндэсний эрх” .сонин, 1935 оны дугаар 76.

[26] “Үнэн” сонин, 1937 он, дугаар 40 (1372)

[27] “Монголын зохиолчдын гуравдугаар их хурал”, Улаанбаатар, 1964 он, 16 дугаар нүүрт.

[28][29] “Ардын Цэнгэлдэх улсын төв театрын энэ 24 ба 25 оны өвлийн цагийн улиралд явуулах ажлын төлөвлөгөө”, 24 оны 12-р сарын 5. МАХН-ын архив, фонд 4, данс 5, хадгаламжийн нэгж 65, Монгол бичгийн машиндмал эх.

[30] С. Буяннэмэх “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв”, “Уран үгсийн чуулган”, эмхтгэл, 1929 он.

[31] С. Буяннэмэх “Театрын уран сайхны тухай”, “Монгол ардын үндэсний соёлын хөгжилийн зам” сэтгүүл, 1934 оны 3 дугаар хугацаа.

[32] С. Буяннэмэх “Утга зохиолын үүд”, Монгол улсын ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэнгийн номын сангийн хадгаламж бүхий 2 дэвтэр гар бичмэл эх, 1935 он, “Хэл зохиол судлал” сэтгүүл, 1975 он, 10 дугаар боть, Ван Мандуга “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл” ном, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 1999 он.

[33] С. Буяннэмэх “Тус улсын 15 жилийн ой ба үндэсний уран сайхны 15 жилийн хөгжил”, “Монгол ардын үндэсний соёлын хөгжилийн зам” сэтгүүл, 1936 оны 5 дугаар хугацаа.

[34][35][36][37] С. Буяннэмэх “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв”, “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл” ном, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 1999 он.

[38][40] С.Буяннэмэх “Утга зохиолын үүд”, Ван Мандуга “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 390,388-389 дүгээр нүүрт.

[39] С.Буяннэмэх “Театрын уран сайхны тухай”, “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл” ном, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 1999 он.185 дугаар нүүрт.

- (Тус өгүүлэл бол << С. Буяннэмэхийн утга урлагийн үзлийн тухай судлал >> хэмээх боловсролын яамны судалгааны сэдвийн явцын бүтээл болно.)

ABSTRACT

The article deals with different aspects of the Buyannemekh's activities, who has brought a tremendous effort and a valuable contribution to the creation of the modern Mongolian theatrical art, has done tireless mental work to compose a great number of plays providing with them the theaters and dramatic clubs and has taught a new generation of the national dramatists. The author comes to the conclusion that S.Buyannemekh is made known as a first modern Mongolian playwright and a first drama theorist. He participated in the originating events of the modern revolutionary dramatics and was one of the first leaders and organizers of the Mongolian theatrical art and produced the first play being performed. The viewpoints of the Buyannemekh's philosophy can be defined in several aspects as follows. Firstly, he pointed out dramatics among the other two genres like poetics and narratives as a more essential one. Secondly, in his opinion the subjects in the dramatics are required to be more directed to the interests of wide masses. Thirdly, he conducted a classification of the dramatics as on documentary, artistic and individual topics. Fourthly, the artistic peculiarities of dramatics are determined as the developments are well-defined and artful, the events are revealed and open, the external form is harmonized with the internal sense. Fifthly, he determines the dramatic writings in three aspects.